



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 25

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дах заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрдэнэдалай сумын Сум дундын эмнэлгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 32-14 ДУА улсын дугаартай, 15,648,000 /Арван таван сая зургаан зуун дөчин найман мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ-3962 маркын автомашиныг тус сумын Бүрэн дунд сургуульд шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Эрдэнэдалай сумын Сум дундын эмнэлгийн эрхлэгч /Д.Батцэцэг/, бүртгэж авахыг Бүрэн дунд сургуулийн захирал /Л.Буянтогтох/-д нарт тус тус даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаярт/-г үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100060